

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЭРДЭМБИЛЭГ ТАНАА

2021.09.25 № 07/4002
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,487,144.00	339,791,050.00
33	АВЛАГА	2,187,144.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,187,144.00	-
34	УРЬДЧИЛГАА	24,300,000.00	339,791,050.00
34600	Урьдчилж гарсан зардал	24,300,000.00	339,791,050.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,487,144.00	339,791,050.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,187,144.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,187,144.00	-
41300	Өглөг	2,187,144.00	-
41360	Бусад өглөг	2,187,144.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,187,144.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,300,000.00	339,791,050.00
51	Засгийн газрын хувь оролцоо	24,300,000.00	339,791,050.00
51200	Хуримтлагдсан үр дүн	24,300,000.00	339,791,050.00
51210	Өмнөх үеийн үр дүн	24,300,000.00	24,300,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	315,491,050.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,487,144.00	339,791,050.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,002,234,700.00	3,003,159,235.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,234,700.00	3,159,235.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,234,700.00	3,159,235.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,234,700.00	3,159,235.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,234,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,159,235.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,000,000,000.00	3,000,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,000,000,000.00	3,000,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,000,000,000.00	3,000,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,002,234,700.00	2,687,668,185.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,002,234,700.00	2,687,668,185.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,002,187,144.00	2,687,668,185.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,002,187,144.00	2,687,668,185.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,002,187,144.00	2,687,668,185.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,556.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,556.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,556.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-	315,491,050.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-	315,491,050.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,002,234,700.00	3,003,159,235.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,234,700.00	3,159,235.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,234,700.00	3,159,235.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,234,700.00	3,159,235.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,234,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,159,235.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,000,000,000.00	3,000,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,000,000,000.00	3,000,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,000,000,000.00	3,000,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,002,234,700.00	3,003,159,235.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,002,234,700.00	3,003,159,235.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,000,000,000.00	3,003,159,235.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000,000.00	3,003,159,235.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000,000.00	3,003,159,235.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,234,700.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,234,700.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,234,700.00	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	24,300,000.00	24,300,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	24,300,000.00	24,300,000.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	24,300,000.00	24,300,000.00
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	24,300,000.00	24,300,000.00
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
16	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
17	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
18	Тайлант үеийн үр дүн	-	-	315,491,050.00	315,491,050.00
19	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	339,791,050.00	339,791,050.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,000,000,000.00	3,000,000,000.00	0.00	100

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд анхан шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Хоёрдугаар газрын аудитын менежер Г.Гүнжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор А.Даваадорж, аудитор Г.Мөнхчимэг нар хариуцаж гүйцэтгэв.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн 2/888 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга, нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

Мөн эрүүл аюулгүй амьдралын орчин бүрдүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийг хамгаалах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх эмийн зохистой хэрэглээ зэрэг үйл ажиллагаанд анхаарч ажилладаг байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,687.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 53.7 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 313.3 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2.2	-	(2.2)
Урьдчилгаа	24.3	339.8	315.5
Нийт хөрөнгө	26.5	339.8	313.3
Өр төлбөр	2.2	-	(2.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	24.3	339.8	315.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	26.5	339.8	313.3

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 2.2 сая төгрөгөөр авлага буурч, урьдчилж гарсан зардал 315.5 сая төгрөгөөр өссөн он дамжсан төсөл арга хэмжээтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,000.0 сая төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэх баталснаас 3,000.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд сангийн хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрт зориулан 3,000.0 сая төгрөгийн төсвийг бараа, үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 110 мэдээлэл, хугацаа болоогүй 6 мэдээлэл, 23.9 сая төгрөгийн 57 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 32.2 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 95 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчилд дараах албан шаардлага хүргүүлээ.
Үүнд:

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ний 05 дугаар тушаалаар сургалт, сурталчилгаанд зарцуулахаар 119.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд шилжүүлэхдээ гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.3 "Иргэн, хуулийн этгээд нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх хүсэлтийг тухайн төсвийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл, 6 дугаар сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр тус тус хүргүүлнэ", 3.5 "Энэ журмын 3.4-т заасан ажлын хэсэг нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авч дууссан хугацаанаас хойш ажлын 30 хоногт багтаан сонгон шалгаруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх.

Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээндээ Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ын дагуу тусгах заалтуудыг бүрэн тусгаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.7 "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон удирдах албан тушаалтан Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй холбогдох гэрээг байгуулж, хяналт тавина. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана", 3.7.1 "үйл ажиллагааны явцын тайлан ирүүлэх хугацаа", 3.7.2 "сангаас санхүүжилт олгох хэлбэр болон хуваарь", 3.7.3 "санхүүгийн тайлан ирүүлэх хугацаа", 3.7.4 "ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх хугацаа" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Урьдчилж гарсан зардал, гэрээт, ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/06/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийг дэмжих сан	Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ний 05 дугаар тушаалаар сургалт, сурталчилгаанд зарцуулахаар 119.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд шилжүүлэхдээ гэрээ байгуулаагүй байна.	-	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Э.Золжаргал, О.Бурмаа
2	Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээндээ Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ын дагуу тусгах заалтуудыг бүрэн тусгаагүй байна.	-	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Э.Золжаргал, О.Бурмаа
ДҮН		-			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 455/20170074

Улаанбаатар хот

САГ-2021/06/СТА-317С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээндээ Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ын дагуу тусгах заалтуудыг бүрэн тусгаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.7 "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон удирдах албан тушаалтан Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй холбогдох гэрээг байгуулж, хяналт тавина. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана", 3.7.1 "үйл ажиллагааны явцын тайлан ирүүлэх хугацаа", 3.7.2 "сангаас санхүүжилт олгох хэлбэр болон хуваарь", 3.7.3 "санхүүгийн тайлан ирүүлэх хугацаа", 3.7.4 "ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх хугацаа" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн хэлтсийн дарга Э.Золжаргал, нягтлан бодогч О.Бурмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Г.МӨНХЧИМЭГ

455/109
0010120395



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 456/10170074
СЭГ-2021/05/СГА-7091

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ний 05 дугаар тушаалаар сургалт, сурталчилгаанд зарцуулахаар 119.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд шилжүүлэхдээ гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ын 3.3 "Иргэн, хуулийн этгээд нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх хүсэлтийг тухайн төсвийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл, 6 дугаар сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр тус тус хүргүүлнэ", 3.5 "Энэ журмын 3.4-т заасан ажлын хэсэг нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авч дууссан хугацаанаас хойш ажлын 30 хоногт багтаан сонгон шалгаруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн хэлтсийн дарга Э.Золжаргал, нягтлан бодогч О.Бурмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Г.МӨНХЧИМЭГ